



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 5154

Улаанбаатар хот

Н.Энхболдыг ажилд томилох тухай


Монгол Улсын "Төрийн албаны тухай" хууийн 10 дугаар зүйлийн 10.1 дэхь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 18 зүйлийн 18.1 дэх заалт, "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5 дахь заалтууд, Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 190 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/45 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нацагдорж овогтой Энхболдыг "Техникч, инженер" албан тушаалд 2013 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 6 сар хүртэлх хугацаагаар, туршилтаар дадлагажуулан ажиллуулсугай.

2. Н.Энхболдын сарын үндсэн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 78 дугаар тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээний дагуу /ТЗ-5-1/ 443,433 /дөрвөн зуун дөчин гурван мянга дөрвөн зуун гучин гурав/ төгрөгөөр цалинжуулж, холбогдох журмын дагуу унаа, хоолны хөнгөлөлтийг олгохыг нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

3. Н.Энхболдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэн ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Ц.Цог/ -т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ч.БАТСАЙХАН



My documents tushaal

1170500107